

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР, ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН БОЛОН НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН  
ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын "Иргэний нисэхийн тухай" хуулийн 29 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Нислэг-Техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба (цаашид шинжлэн шалгах алба гэх), Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн хамтран энэ харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулав.

Талууд мэдэгдэх нь:

1. Шинжлэн шалгах албаны үйл ажиллагааны үндсэн зорилт нь иргэний нисэхийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, осол, зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зөвлөмж боловсруулахад орших бөгөөд гэм бурууг хуваарилаж, хариуцлага хүлээлгэхэд чиглэхгүй болно.
2. Иргэний агаарын хөлгийн ослыг шалгахдаа агаарын тээврийн байгууллагуудын нислэгийн аюулгүй ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, аюулгүй байдлаар өрсөлдөх чадварыг дээшлүүлэх шаардлагыг гол үндэс болгосон нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хамтын ажиллагаа байна.
3. Агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах ажиллагаанаас олж авсан мэдлэг, туршлага дээр үндэслэн талууд ослын үед хамтран ажиллах системийг бий болгон тогтоож осол гарсан тохиолдолд өөрсдийн мэдлэг, мэдээлэл, тоног төхөөрөмжийн эх үүсвэрүүдийг үр дүнтэйгээр ашиглахад дэмжлэг үзүүлснээр иргэний нисэхийн аюулгүй ажиллагаанд хувь нэмрээ оруулна.

## 1. ЗОРИЛГО

1.1 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь ослыг шалгах чиглэлээр талуудын томилогдсон багуудын хоорондын зүй зохистой, хамтын ажиллагаанд зайлшгүй шаардлагатай асуудлыг тусгахад оршино.

## 2. ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт дараах тодорхойлолтын илэрхийллийг хэрэглэсэн болно.

- 2.1.1 Осол гэж Чикакогийн конвенцийн 13 дугаар хавсралтад тодорхойлсноор илэрхийлэгдэнэ.
- 2.1.2 Ноцтой зөрчил гэж осолд хүргэх дөхсөн аливаа зөрчил (Чикакогийн конвенцийн Хавсралт 13-ын нэмэлт "С" болон ICAO-гийн Дос 9156) буюу "ослын нөхцөлбайдалд хүргэж болзошгүй зөрчлийг" гэж заасан тодорхойлолтоор ойлгоно.
- 2.1.3 агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгах гэдэг нь Монгол Улсын "Иргэний нисэхийн тухай" хуулийн 3.1.21"-д зааснаар гарч болзошгүй нислэг-техникийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, түүнчлэн гарсан осол зөрчлийн шалтгааныг тогтоон аюулгүй ажиллагааны зөвлөмж бэлтгэх үйл ажиллагаа.
- 2.1.4 Шинжлэн шалгах баг гэж урьдчилан зохион байгуулагдаж, техник хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хангалт хийгдэж, сургалт дадлаганд хамрагдсан шинжээч.

2.1.5. Бодит байдал гэж агаарын хөлгийн ослын үйл явдлын өрнөл, гарсан нөхцөл, алга болсон байдал нотолгоог нэгтгэснийг.

### 3. ХАМТЫН АЖИЛЛАГАА

3.1. Талууд дараах асуудал бүрээр хамтран ажиллана.

- Мэдээлэл солилцох
- Ослын газарт хяналт тогтоох
- Үзлэг хийж нотлох баримт олж авах
- Шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийх
- Сургалт, дадлагад хамтарсан байдлаар оролцох
- осолд өртсөн агаарын хөлгийн нисэх баг, зорчигчид болон бусад шаардлагатай хүмүүст эмнэлгийн үзлэг хийх

### 4. ИРГЭНИЙ АГААРЫН ХӨЛГИЙН ОСЛЫГ ШИНЖЛЭН ШАЛГАХ ЗАРЧИМ

- 4.1. Иргэний агаарын хөлгийн ослыг шалгахдаа шинжлэн шалгагч, мөрдөн байцаагч, шинжээч тус бүрийн шалгах үйл ажиллагааны чиг үүрэг, зарчим, байгууллага тус бүрийн хүлээх хариуцлага, гаргах шийдвэр хараат бус бие даасан байдал хуульчлагдсан гэдэгт санал нийлнэ.
- 4.2. НТОЗШША-ны шинжлэн шалгагчид нь ослын үндсэн шалтгаан техник, технологи, зохион байгуулалт, удирдлагын бичиг баримт, оролцогчдын үйл ажиллагаатай холбоотой шалтгааныг илрүүлэн тогтоож урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргахдаа хууль хяналтын байгууллагаас хараат бус бие даасан байна.
- 4.3. Мөрдөн байцаах байгууллага осол хаана хэрхэн болсон, мэдээлэл, баримт, нотолгооны материал цуглуулах, гэм буруутанг олж тогтоох ажлыг Монгол Улсын ЭБШХ-д заасан үндэслэл, журмыг баримтлан удирдаж явуулна.
- 4.4. Хохирогдогсад, амь үрэгдэгсдийг тогтоох, таниулах ажиллагаанд талууд хамтран ажиллах, нотлох баримтыг хамгаалах, нислэгийн бодит хяналтын төхөөрөмжийг хайж олж авах, түүнийг **шинжилгээнд явуулах, бичлэг тайлах зорилгоор НТОЗШША-нд шилжүүлж өгөх**,
- 4.5. Талууд өөрсдийн зохион байгуулсан шинжлэн шалгах сургалт, дадлаганд нөгөө талынхаа шинжлэн шалгагчдыг урьж оролцуулж болно.

### 5. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ

5.1. Агаарын хөлгийн ослыг шалгах үед олж авсан нислэгийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн мэдээллийг талууд солилцоно.

5.2. Мэдээллийг нийтэд нээлттэй болгох хүртэл талууд харилцан солилцсон мэдээллийн нууцыг хадгална.

### 6. НИСЭХИЙН ОСЛЫН ГАЗАРТ ХИЙХ ХЯНАЛТ

6.1. Агаарын хөлгийн ослын газарт шинжлэн шалгах алба хориотой бүсийг тогтоож, ослын газарт нэвтрэх ажлыг удирдан зохион байгуулна.

6.2. Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч нь шаардлагатай гэж үзвэл агаарын хөлгийн ослын газарт хориотой бүс тогтоох ба энэ тухайгаа шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчдын багтай урьдчилан тохиролцено.

## 7. БАРИМТ ОЛЖ АВАХ

7.1. Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч нь агаарын хөлгийн ослын талаар хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий шаардлагатай баримт, материал олж илрүүлэн хураан авах эрхтэй байх ба шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч нь нислэгийн аюулгүй байдлыг хангах, ослын шалтгааныг тогтоох, судалгааны баримт материал олж авах хадгалах, ашиглахдаа өөр өөрийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хамтран ажиллана.

7.2. Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч болон шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчид агаарын хөлгийн ослын судалгаа, холбогдох материалын талаар харилцан хүсэлт гаргавал шаардлагатай баримтаар хангаж болно.

7.3. Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч нь өөрийн олж авсан баримтандaa юмуу нислэгийн өгөгдэхүүн бичигчийн шалгалтын үр дунд тайлбар хийлгэхийг хүсвэл шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчид тухай бүрт нь хүсэлтийг хангаж байх болно.

## 8. ЦОГЦОСТ ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

8.1 Шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагчид болон хууль хяналтын байгууллагын шинжлэн шалгах багийн гишүүд болон прокурорын зүгээс үхлийн гэмтэл авсан цогцост патологийн задлан шинжилгээ хийх, амьд үлдсэн нисэх багийн гишүүдэд эмнэлгийн үзлэг хийх ажлыг хамтран зохион байгуулна.

## 9. ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА

9.1 Энэхүү санамж бичиг нь Талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байх бөгөөд аль тал өөрчлөх тухай санал албан тоотоор гаргаагүй тохиолдолд мөн хугацаагаар сунгагдсанд тооцогдоно.

Энэхүү санамж бичиг нь дараах тохиолдолд хүчингүй болно:

- Талууд хүчингүй гэдэгт санал нэгдвэл
- Энэхүү санамж бичиг хүчингүй болгох талаар нэг тал нь нөгөө талдаа албан тоотоор мэдэгдвэл

## 10. БУСАД АСУУДАЛ

Энэ санамж бичгийг хэрэгжүүлэх явцад санал зөрөх, маргаантай асуудал үүсвэл талууд хамтран нэгдсэн шийдвэр гаргана.

Харилцан төхиролцсон:

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Д. САНДАГ-ОЧИР

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

Ч. АЛТАНХИШИГ

НИСЛЭГ-ТЕХНИКИЙН  
ОСОЛ ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ  
АЛБАНЫ ДАРГА

Х. НАРАНХҮҮ

200 9. оны 9. дугаар сарын 04.-ны өдөр